

МӨНГӨНИЙ ТОЙМ

2016 оны 10 дугаар сар

ХУРААНГУЙ:

- Тухайн сард мөнгөний нийлүүлэлт (M2) 0.5 хувь буюу 56.1 тэрбум төгрөгөөр өсч 11.5 их наяд төгрөгт хүрчээ. Мөнгөний нийлүүлэлт дэх M1 мөнгөний хувийн жин 0.6 нэгж хувиар нэмэгдэж 17.4 хувьд хүрэв.
- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 40 дүгээр тогтоолын дагуу Ирээдүйн тэтвэрийн нөөц сангийн өмчлөгчид шилжүүлсэн, шинээр үүссэн орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас болон ипотекийн зээлийг санхүүжүүлэх зориулалтаар Монголбанкнаас банкинд олгосон зээлийн шаардах эрхийн өмчлөл, түүнтэй холбоотой бусад хөрөнгийг Монголбанкинд буцаан шилжүүлэв.
- Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 230.1 тэрбум төгрөгөөр өсч 19.5 их наяд төгрөгт хүрлээ. Зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.6 нэгж хувиар өсч 10.8 хувьд хүрсэн байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн дийлэнхийг хувийн хэвшилд олгосон зээл эзэлж байна.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

		2013	2014	2015	2016			
		12-р сар	12-р сар	12-р сар	3-р сар	6-р сар	9-р сар	
Улаанбаатар хотын инфляци	<i>сарын</i>	1.7	0.6	-0.2	0.3	-0.5	-0.9	-1.2
	<i>оны эхнээс</i>	11.2	10.7	1.1	1.5	2.7	0.1	-1.1
	<i>жилийн</i>	11.2	10.7	1.1	1.1	1.2	-0.7	-0.8
Суурь инфляци	<i>сарын</i>	1.3	0.4	-0.1	-0.4	-0.1	0.3	-0.1
	<i>оны эхнээс</i>	12.1	12.6	4.8	-1.1	-1.2	-1.0	-0.8
	<i>жилийн</i>	12.1	12.6	4.8	3.1	3.0	0.8	0.4
Улсын инфляци	<i>сарын</i>	0.7	0.8	-0.2	0.5	-0.3	-0.6	-0.7
	<i>оны эхнээс</i>	11.9	11.0	1.9	1.7	2.9	0.6	-0.1
	<i>жилийн</i>	11.9	11.0	1.9	1.7	1.6	-0.1	-0.1
Нөөц мөнгө, тэрбум ₮		3,335.5	3,426.5	2,459.6	2,360.7	3,526.1	3,096.4	2,933.9
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>		18.1	27.9	17.9	2.3	10.0	-4.9	-5.2
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>		54.0	2.7	-28.2	-4.4	49.9	28.5	33.8
M2 мөнгө, тэрбум ₮		9,454.9	10,635.8	10,050.2	10,113.7	11,188.2	11,450.1	11,506.3
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>		3.9	7.1	2.5	1.0	5.0	1.6	0.5
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>		24.2	12.5	-5.5	2.1	11.4	15.3	16.2
Бусад хадгаламж, тэрбум ₮		7,361.7	8,819.1	8,364.8	8,530.0	9,206.8	9,519.7	9,499.7
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>		1.2	7.0	1.4	0.4	3.3	1.7	-0.2
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>		27.4	19.8	-5.2	0.9	9.9	14.4	14.9
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум ₮		841.1	809.7	706.7	658.6	839.2	795.8	806.5
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>		4.6	5.3	-0.5	0.5	6.5	-2.6	1.3
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>		1.5	-3.7	-12.7	-6.3	11.0	3.6	9.0
Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮		12,570.6	16,566.6	17,915.5	18,414.3	18,411.2	19,240.1	19,470.2
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>				0.5	1.5	1.7	0.6	1.2
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>		-99.8	31.8	8.1	8.1	7.3	8.1	9.8
Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮		10,771.2	12,503.5	11,706.6	11,840.1	12,031.3	12,490.9	12,565.4
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>		-99.9	-1.2	-1.6	1.7	5.1	0.4	0.6
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>		-99.8	16.1	-6.4	-3.5	0.6	4.6	5.4
Хадгаламжийн байгууллагуудын чанаргүй зээл, тэрбум ₮		566.0	625.7	869.8	967.9	1,035.6	1,119.3	1,140.1
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>		-99.9	0.9	0.5	6.2	-2.6	-0.6	1.9
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>		-99.8	10.6	39.0	37.7	33.8	31.3	30.9
Хадгаламжийн ЖДХ		12.1	12.5	13.3	13.3	13.3	13.2	13.3
Зээлийн ЖДХ**		17.4	19.5	19.1	19.7	19.1	20.1	20.2
Ипотекийн зээлийн хүү		9.90	9.90	8.82	8.81	7.74	8.68	9.06
ТБҮЦ-ны ЖДХ		10.5	12.1	13.0	12.0	10.5	16.0	16.2
Бодлогын хүү		10.50	12.00	13.00	12.00	10.50	15.00	15.00
БХЗ-ын ЖДХ		8.91	12.20	11.84	12.55	11.33	15.87	15.51

* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

** Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт


Тухайн сард М2 мөнгөний нийлүүлэлт 0.5 хувь буюу 56.1 тэрбум төгрөгөөр өсч 11.5 их наяд төгрөгт хүрчээ.

Тухайн сард хувийн хэвшлийн төгрөгийн харилцах 75.1 тэрбум төгрөгөөр өссөнөөр М2 мөнгөний нийлүүлэлт дэх М1 мөнгөний хувийн жин 0.6 нэгж хувиар нэмэгдэж 17.4 хувьд хүрэв.

Нийт хадгаламж, гадаад валютын харилцахын дүн өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Энэ нь гадаад валютын харилцах 193.4 тэрбум төгрөг (13.7 хувь)-өөр буурсан ч гадаад валютын хадгаламж 127.3 тэрбум (5.2 хувь), иргэдийн төгрөгийн хадгаламж 56.8 тэрбум төгрөг (1.1 хувь)-өөр өссөнтэй холбоотой юм.

Гадаад валютын харилцахын бууралтад бусад санхүүгийн байгууллагуудын¹ банкууд дахь харилцах 132.0 тэрбум төгрөгөөр багассан нь голлон нөлөөлөв. Мөн гадаад валютын хадгаламж болон харилцахын өсөлтөд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өөрчлөлт нөлөө үзүүлж байгаа бөгөөд ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцвол валютын хадгаламжийн сарын өсөлт 1.2 хувь, харин валютын харилцах 17.0 хувийн бууралттай байна.

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн задаргаа, тэрбум ₮



Зураг 2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт



Санхүүгийн байгууллагуудын тойм

Тайлант сард хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив 363.2 тэрбум төгрөгөөр буурч -4507.7 тэрбум төгрөг болжээ. Үүнд арилжааны банкуудын гадаад актив 187.2 тэрбум төгрөгөөр буурч, гадаад пассив 113.7 тэрбум төгрөгөөр өссөн нь голчлон нөлөөлөв.

Тайлант сард Төв банкны бусад санхүүгийн байгууллагуудаас авах авлага 1950.1 тэрбум, өөрийн хөрөнгийн сангууд 2325.9 тэрбум, хадгаламжийн байгууллагуудаас авах авлага 714.6 төгрөгөөр нэмэгдэж, Засгийн газраас авах авлага 527.4 тэрбум төгрөгөөр буурав. Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 40 дүгээр тогтоолын дагуу Ирээдүйн тэтвэрийн нөөц

Зураг 3. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив




¹ Бусад санхүүгийн байгууллагад ОУВС-ийн Мөнгө, санхүүгийн статистикийн аргачлал (MFSM, 2000)-ын дагуу банк бус санхүүгийн байгууллагууд, МИК ОССК, Монгол улсын Хөгжлийн банкнийг оруулна.

сангийн өмчлөгчид шилжүүлсэн, шинээр үүссэн орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас болон ипотекийн зээлийг санхүүжүүлэх зориулалтаар Монголбанкнаас банкинд олгосон зээлийн шаардах эрхийн өмчлөл, түүнтэй холбоотой бусад хөрөнгийг Монголбанкинд буцаан шилжүүлсэнтэй холбоотой юм.

Тайлант сард нөөц мөнгө 5.2 хувь буюу 162.4 тэрбум төгрөгөөр буурав. Энэ нь банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж 173.1 тэрбум төгрөг (7.5%)-өөр буурсантай холбоотой юм. Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкуудын касс дахь мөнгө төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Зураг 4. Нөөц мөнгө




ЗЭЭЛ


Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 230.1 тэрбум төгрөгөөр өсч 19.5 их наяд төгрөгт хүрчээ. Үүний 39.7 хувийг иргэд, 39.4 хувийг хувийн хэвшил, 20.9 хувийг улсын байгууллагуудад олгосон зээл эзэлж байна. Тухайн сард зээлийн үлдэгдэл өсөхөд улсын байгууллагууд болон хувийн хэвшилд олгосон зээлийн үлдэгдэл харгалзан 130.5 тэрбум төгрөг, 127.2 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлөв. Харин иргэдийн зээлийн үлдэгдэл 23.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.6 нэгж хувиар өсч 10.8 хувьд хүрсэн байна. Харин чанаргүй зээлийн хувь 0.1 нэгж хувиар өсч 5.9 хувь болжээ. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн дийлэнхийг хувийн хэвшилд олгосон зээл эзэлж байна. Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийг тусад нь авч үзвэл хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь 7.1 хувь, чанаргүй зээлийнх 9.1 хувь байна. Татан буугдсан банкуудын мэдээлийг хасч тооцвол чанаргүй зээлийн эзлэх хувь 7.6 хувь байна.

Зураг 5. Санхүүгийн байгууллагуудын зээл



Зураг 6. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Мөнгөний зах

Тухайн сард арилжааны банкууд банк хоорондын захаар дамжуулан 629.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 43.4 хувийг овернайт зээл, 26.5 хувийг репо арилжаа, 16.1 хувийг банк хоорондын хадгаламж, 14.1 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа бүрдүүлжээ.

Банкууд 2016 оны 9 дүгээр сарын 28-наас 10 дугаар сарын 26-ны өдрийн хооронд төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлага хангах зорилгоор 1034.8 тэрбум төгрөг, гадаад валютын заавал байлгах нөөцийн шаардлага хангах зорилгоор 1045.7 тэрбум төгрөгийг Монголбанк дахь харилцах дансандаа төвлөрүүлжээ.

Зураг 7. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү



Хүү

Төгрөгийн харилцах, хадгаламжийн хүү харьцангуй тогтвортой байгаа бөгөөд тайлант сарын эцэст төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж жилийн хүү 2.7 хувь, төгрөгийн хадгаламжийнх 13.3 хувь байна. Харин гадаад валютын хадгаламжийн жигнэсэн дундаж жилийн хүү өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурч 6.2 хувь болжээ.

Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж жилийн хүү өмнөх сараас 0.1 нэгж хувиар өсч 20.2 хувь болов. Харин зээлийн үлдэгдлээр жигнэсэн дундаж зээлийн хүү өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурч 18.1 хувь байна.

Банк хоорондын захын хүү 2016 оны 8-9 дүгээр сард эрс өссөн бол 10 дугаар сард 0.4 нэгж хувиар буурчээ. Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй бол Засгийн газрын 12 долоо хоногтой үнэт цаасны хүү 1.0 нэгж хувиар өсч 16.7 хувьд хүрэв.


Зураг 8. Хүү



Валютын ханш

Тайлант сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3.8 хувь буюу 86.9 төгрөгөөр суларч 2374.21 болжээ. Тухайн сард төгрөгийн евротой харьцах ханш 33.3 төгрөг, Хятадын юаньтай харьцах ханш 7.3 төгрөгөөр суларсан ч английн фунттай харьцах ханш 69.8 төгрөгөөр чангарсан байна. Тайлант сарын эцэст төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 2.2 хувиар буурсан буюу төгрөгийн ханш суларчээ.

Зураг 8. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100




Инфляци

2016 оны 10 дугаар сарын инфляци улсын хэмжээнд -0.7 хувь байсан бөгөөд үүний -0.8 нэгж хувийг хүнсний барааны бүлгийн үнийн өөрчлөлт эзэлж байна.

Сарын инфляцийн 0.1 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээ (орон сууц, ус, цахилгаан, түлш)-ний үнийн өөрчлөлт бүрдүүлжээ. Хүнснээс бусад бараа, үйлчилгээний сарын инфляци 2015 оны 11 дүгээр сараас хойш 0 хувийн орчимд хэлбэлзэж байна. Харин хүнсний барааны хувьд өмнөх онуудын адил улирлын хэлбэлзэл ажиглагдаж байна.

Зураг 9. Улсын сарын инфляци



Жилийн инфляци улсын хэмжээнд 2016 оны 10 дугаар сарын байдлаар -0.1 хувь байгаа бөгөөд үүний -0.6 нэгж хувийг хүнсний барааны бүлгийн жилийн инфляци, 0.5 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээний жилийн инфляци бүрдүүлж байна.

Зураг 10. Улсын жилийн инфляци

